

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2016 оны 12 дугаар сарын 28-ний
өдрийн 4 дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт

ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙ, ГАЗРЫН ТОС, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

1116127151
УХА0580 9129294

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрмээр Геологи, Уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын Шинжлэх ухаан, технологийн орон тооны бус зөвлөл (цаашид "Зөвлөл" гэнэ) -ийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг зохицуулна.

1.2. Зөвлөлийн үйл ажиллагааны зорилго нь геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын шинжлэх ухаан, технологийн бодлогын чиглэлийг тодорхойлох, судалгаа, шинжилгээ, туршилтын үр дүнд үнэлэлт дүгнэлт өгөх, хүнд үйлдвэр байгуулах техник-эдийн засгийн үндэслэл, инженерийн зураг төсөл зэргийг хэлэлцэж, холбогдох хууль, дүрэм, судалгааны арга, аргачлал, стандарт, норм, нормативтай нийцэж буй эсэх талаар мэргэжлийн үнэлэлт, дүгнэлт өгөх, үйлдвэрлэл, шинжлэх ухааны уялдаа холбоог хангах, сургалт, судалгаа, үйлдвэрлэлийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд оршино.

Хоёр. Зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт

2.1. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг "Шинжлэх ухаан, технологийн хууль"-ийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт заасны дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалаар томилж, ажиллуулна.

2.2. Зөвлөлийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд даргална.

2.3. Зөвлөл нь Геологи, уул уурхай, газрын тосны салбар хуралдаан, Хүнд үйлдвэрийн салбар хуралдаан гэсэн хоёр салбар хуралдаантай байна.

2.4. Салбар хуралдааны үйл ажиллагааг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны газрын дарга /салбар хуралдааны дарга/ нар зохион байгуулна.

2.5. Шаардлагатай тохиолдолд хоёр салбар хуралдаан хамтарч хуралдана.

2.6. Салбар хуралдааны бүрэлдэхүүн тус бүр дарга, 12- оос ихгүй гишүүн, саналын эрхгүй нарийн бичгийн даргатай байна. Бүрэлдэхүүнд холбогдох яам, төрийн байгууллагын албан тушаалтан, салбарын судлаач эрдэмтэн, зөвлөх, мэргэшсэн инженер, үйлдвэрлэгчдийн төлөөлөл багтана.

Гурав. Зөвлөлийн үйл ажиллагаа

3.1. Геологи, уул уурхай, газрын тосны салбар хуралдааны үйл ажиллагаа дараах зарчмыг баримталж ажиллана: Үүнд

3.1.1 Үндэсний аюулгүй байдал, хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажил явуулахгүй байх;

3.1.2 Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд оролцогч нь эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын чиглэл, тэдгээрийг хэрэгжүүлэх арга, хэлбэрийг чөлөөтэй сонгох, хэрэгжүүлэх;

3.1.3 Нууцын зэрэглэлд хамаарахаас бусад эрдэм шинжилгээний ажил, түүний шалгаруулалт нь чөлөөт өрсөлдөөнд үндэслэсэн ил тод, шударга, нээлттэй байх;

3.1.4 Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд иргэд, хуулийн этгээд тэгш

эрхтэй, чөлөөтэй оролцох;

3.1.5 Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа нь үр ашигтай, бүтээмжтэй байх.

3.2 Хүнд үйлдвэрийн салбар хуралдааны үйл ажиллагаа дараах зарчмыг баримталж ажиллана:

3.2.1. эдийн засгийн хөгжилд үр өгөөжтэй байх;

3.2.2. түүхий эдийг бүрэн боловсруулах, хаягдалгүй технологийг нэвтрүүлэх;

3.2.3. байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах;

3.2.4. технологийн дэвшлийг бий болгохдоо тухайн техник, технологийн онцлогийг харгалзах;

3.2.5. дэд бүтэц, эрчим хүч, ус болон бусад нөөцийн ашиглалтыг зүй зохистой байлгах;

3.2.6. бүтээгдэхүүний чанар стандартын шаардлага хангасан байх;

3.2.7. үйлдвэрийн боловсон хүчнийг дадлагажуулж бэлтгэх, чадварыг нэмэгдүүлэх;

3.3. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Үүнд:

3.3.1. Геологи, уул уурхай, газрын тосны салбар хуралдааныг урьдчилан тогтоосон графикайн дагуу хийнэ. Шаардлагатай үед зөвлөлийн даргын санаачлагаар ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно.

3.3.2. Хүнд үйлдвэрийн салбар хуралдааныг тухай бүр зарлан хуралдуулна.

3.4. Хуралдааныг зөвлөлийн дарга удирдан явуулна. Түүнийг эзгүйд салбар хуралдааны дарга удирдан явуулж болно;

3.5. Зөвлөл нь зөвлөмж, дүгнэлтийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ;

3.6. Зөвлөлийн хуралдааныг монгол хэл дээр явуулж, түүний баримт бичгийг монгол хэлээр гаргана. Зөвлөлийн хуралдааны тэмдэглэл, шийдвэр, бусад холбогдох материал Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны архивт хадгалагдана.

3.7. Зөвлөлийн гишүүдийн гуравны хоёроос доошгүй ирцтэй хуралдааныг хүчинтэйд тооцно.

3.8. Хуралдаанд оролцсон гишүүдийн үнэмлэхүй олонхийн (75-аас доошгүй хувийн) саналыг үндэслэн хуралдаанаас холбогдох шийдвэр гаргана. Хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй гишүүн нь хуралдаанаас гарах шийдвэрээс татгалзах, түүнд тайлбар өгөх эрхгүй. Гишүүн нь хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралд оролцох боломжгүй үед өөрийн саналыг бичгээр өгч болно. Гарсан шийдвэрийг зөвлөлийн дарга батламжилна.

3.9. Хуралдаанаар хэлэлцүүлэх асуудалтай холбогдолтой материалыг зөвлөлийн нарийн бичгийн дарга асуудал хариуцагчтай хамтран бэлтгэж, зөвлөлийн даргад урьдчилан танилцуулж, хуралдах өдрөөс 3 хоногийн өмнө гишүүдэд хүргэсэн байна.

3.10. Хуралдаанд хэлэлцүүлэхээр ирүүлэх материал нь Монгол хэл дээр байна. Хэрэв хуралдаанаар хэлэлцүүлэх материал нь гадаад хэл дээр бичигдсэн бол Монгол хэл рүү орчуулж, гадаад хэл дээрх эхийн хамт ирүүлнэ.

3.11. Салбар хуралдаанд шаардлагатай тохиолдолд УИХ, Засгийн газрын гишүүд, яам, агентлаг, эрдэм шинжилгээний байгууллага зэргээс холбогдох албан тушаалтан, мэргэжилтнүүдийг урилгаар оролцож болох ба хүмүүсийн бүрэлдэхүүнийг Зөвлөлийн дарга, салбар хуралдааны дарга тогтооно.

3.12. Зөвлөлийн хуралдаанаас гарсан санал, шүүмж, зөвлөмжийн дагуу засварлах, сайжруулах үүргийг асуудал хэлэлцүүлсэн субъект хүлээх ба хуралдаанаар дахин хэлэлцүүлж шийдвэр гаргуулна.

3.13. Зөвлөлийн хуралдааны үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг яамны төсвөөс санхүүжүүлнэ.

Дөрөв. Салбар хуралдааны хэлэлцэх асуудал

4.1. Геологи, уул уурхай, газрын тосны салбар хуралдаанаар дор дурьдсан асуудлуудыг хэлэлцэн зөвлөмж, дүгнэлт гаргана. Үүнд:

4.1.1. салбарын эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны байгууллага, үйлдвэр, аж ахуйн нэгж дээр хэрэгжиж буй судалгааны ажил, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн бодлоготой уялдаатай төслийн судалгаа, шинжилгээ, туршилтын явц, гүйцэтгэл, тайлан, мэдээ;

4.1.2. Шинжлэх ухаан технологийн сангаас санхүүжигдэх шинээр хэрэгжүүлэхээр санал болгож буй төслүүд.

4.1.3. хуульд заасан бусад асуудлууд.

4.2. Хүнд үйлдвэрийн салбар хуралдаанаар дор дурьдсан асуудлуудыг хэлэлцэн зөвлөмж, дүгнэлт гаргана. Үүнд:

4.2.1. салбарын боловсруулах үйлдвэрлэлийн болон технологийн хөгжлийн бодлоготой уялдаатай эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны байгууллага, үйлдвэр, аж ахуйн нэгж дээр хэрэгжиж буй төсөл, судалгааны ажил, техник-эдийн засгийн үндэслэл, бүтээгдэхүүний стандарттай холбоотой асуудал, шинжилгээ, туршилтын явц, гүйцэтгэл, тайлан, мэдээ;

4.2.2. Үйлдвэрлэлийн технологийн патенттай холбоотой асуудлууд;

4.2.3. Үйлдвэрлэлийн төслийн менежментийн асуудлууд;

4.2.4. Хүнд үйлдвэрлэлийн салбарт мөрдөх дүрэм, журам, норм, норматив техникийн зохицуулалт, бүтээгдэхүүний стандартууд, техникийн шинэ шийдэл, судалгааны ажилд хэрэглэх норм, үнэлгээ;

4.2.5. Хүнд үйлдвэрийн салбар дахь хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, аюулгүй ажиллагаатай холбоотой асуудлууд;

4.2.6. Үйлдвэрлэлийн дэд бүтэц, хөрөнгө оруулалт, эрсдлийн үнэлгээний тайлан;

4.2.7. Бүтээгдэхүүний борлуулалтын зах зээлийн судалгааны тайлан;

4.3. Хүнд үйлдвэрийн салбарын техник-эдийн засгийн үндэслэлд тавигдах шаардлага, хүлээн авах журмыг Хүнд үйлдвэрийн салбар хуралдааны гишүүд боловсруулж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн Сайдаар батлуулна.

Тав. Зөвлөлийн хуралдаанд шинжээч оролцуулах

5.1. Зөвлөл нь хөндлөнгийн хяналт хийж, шүүмж, дүгнэлт гаргах итгэмжлэгдсэн мэргэшсэн шинжээч болон шинжээчдийн багийг зөвлөлийн нэрийн өмнөөс томилон ажиллуулж болно.

5.2. Тухайн тайлан, техник-эдийн засгийн үндэслэлд шүүмж хийж, дүгнэлт гаргах итгэмжлэгдсэн шинжээчийг салбар хуралдааны даргын санал болгосноор зөвлөлийн дарга томилно. Зөвлөлийн гишүүн итгэмжлэгдсэн шинжээч байж болно.

5.3. Шинжээчийн дүгнэлтэд Зөвлөл хариуцлага хүлээхгүй.

5.4. Шинжээч ажлын тайлан, материалтай нарийвчлан танилцан, шаардлагатай бол газар дээр нь очиж, шалган баталгаажуулж шүүмж, дүгнэлтээ үнэн, зөв, бодитой хийж, тайлан зохиогч болон зөвлөлийн нарийн бичгийн даргад ирүүлэх ба Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх үед өөрийн биеэр оролцоно.

5.5. Шүүмж, дүгнэлт гаргасан шинжээч нарт холбогдох зардлыг хуралдаанаар асуудал хэлэлцүүлсэн тал хариуцна.

Зургаа.Зөвлөлийн эрх, үүрэг, хориглох зүйл.

6.1. Зөвлөл нь дараах бүрэн эрхтэй:

6.1.1. Салбарын эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны байгууллага, үйлдвэр аж ахуйн нэгж дээр хэрэгжиж буй судалгааны ажил, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн бодлоготой уялдаатай төслийн талаар хүлээж авах асуудлаар шийдвэр гаргах;

6.1.2. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр ирүүлсэн тайлан, материалын бүрдэлт бүрэн бус, мөрдөж байгаа заавар, журмын шаардлагыг хангаагүй бол төсөл боловсруулагчид буцаах, Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх явцад буцаахаар шийдвэрлэсэн тайлан, материалд нэмэлт засвар, тодотгол хийлгэх, эсхүл уг тайлан, материалыг дахин шинээр боловсруулах хугацааг тогтоох, хэлэлцэх тайлан, материалтай холбогдсон нэмэлт тайлбар, мэдээллийг төсөл боловсруулагчаас гаргуулах;

6.1.3. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудалтай шууд холбоотой хувь хүн, эрдэмтэд, мэргэжилтнүүдийг Зөвлөлийн хуралдаанд урьж, зөвлөх эрхтэй оролцуулах;

6.1.4. Эрдэм шинжилгээний туршилт, судалгаа, зохион бүтээх ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх ажлын менежментийг боловсронгуй болгох, ажлын явц, үр дүнг сурталчлах, мэдээлэх, үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

6.1.5. Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, мэргэжлийн холбоо, тэргүүлэх үйлдвэрүүдийн хамтран ажиллах, салбар хоорондын шинжлэх ухааны байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

6.1.6. Хуульд заасан бусад эрх

6.2. Зөвлөл дараах үүргийг хүлээнэ:

6.2.1. Зөвлөл хэлэлцсэн асуудал бүрээр хуралдааны тэмдэглэл хөтөлж, Эрдэс баялгын салбарт баримтлах бодлого, Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого, холбогдох хууль тогтоомж, хөтөлбөрийн хүрээнд зөвлөмж, дүгнэлт гаргах;

6.2.2. Өмнө хийгдсэн төслийг үйлдвэрлэгч нарт мэдээлэх, эргэлтэд оруулах тогтолцоог бий болгох чиглэлээр санал боловсруулах;

6.2.3. Салбарын шинжлэх ухаан, технологийн бодлогын хэрэгжилтийг сурталчлах, мэдээлэх, их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран ажиллах;

6.2.4. Салбарт хэрэгжүүлэх нэн шаардлагатай төслүүдийг хэлэлцэн, үнэлгээ хийх;

6.2.5. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудал, гаргасан холбогдох шийдвэр биелэлтийн талаар /УУХҮЯ/-ны Удирдлагын зөвлөлд танилцуулах.

6.3. Зөвлөлийн гишүүнд хориглох зүйл:

6.3.1. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг зөрчих.